

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД “TASER X-26” ЗАГВАРЫН ЦАХИЛГААН ГҮЙДЛЭЭР ЦОХИГЧ БУУГ АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

THE DEMANDS AND SOME ISSUES OF LEGAL REGULATION TO USE ELECTROSHOCK WEAPON “TASER X-26” WHICH DELIVERS ELECTRICAL CURRENT FOR THE ACTIVITIES OF POLICE



Ш.ЧУЛУУН

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах
багш, докторант, цагдаагийн хошууч

CHULUUN SH.

Senior Lecturer of the Police law department, Law
Enforcement University, Ph.D student, Police major

Товч агуулга: Дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжингүй орнуудын цагдаа болон хууль сахиулах байгууллагын албаны үйл ажиллагаанд ашигладаг “Taser X-26” загварын цахилгаан бууг гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд гэмт этгээдэд хэрхэн ямар байдлаар хэрэглэдэг, ач холбогдол, үр дүнг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх арга зам, хэрхэн ямар байдлаар дотоодын эрх зүйн зохицуулалтанд тусгах талаар өөрийн саналыг дэвшүүлсэн болно.

Abstract: The electroshock weapon “Taser X-26” is used in the official activities of police and law enforcement in the developed and developing countries in the world. I have proposed some of my ideas on how to use this weapon during the activities against crime and criminals, how to mention in the local legal regulations and which way to implement after identifying its results and importance.

Шинэчлэлийн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хууль сахиулах салбарын эрх зүйн шинэчлэлийн ажлын хүрээнд 2013 онд Цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулж “Цагдаагийн албаны тухай” хууль батлагдсан бөгөөд уг хуульд нийцүүлэн цагдаагийн байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлэн ажилллаж байна.

Тус хуулинд цагдаагийн байгууллага, алба хаагчийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх талаар дараах зохицуулалт тусгагджээ.

Тухайлбал: Цагдаагийн байгууллага, алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хуульд заасан үндэслэл журмындагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэнэ¹, Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр

¹ Цагдаагийн албаны тухай хууль 2013 оны 07-р сарын 05-нд батлагдсан 9 бүлэг, 42 зүйлтэй хууль юм. Энэ хууль 2014 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

² Цагдаагийн албаны тухай хуулийн 33-р зүйлийн 33.6 дахь заалт

цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дүрс, дуу бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдах бөгөөд хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэнэ³, Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх алба хаагчид галт зэвсэг олгох, алба хаагч нь галт зэвсгийг биедээ авч явах эрхтэй гэж тус тус заасан байна.⁴

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Нарангэрэл “Агсамж гэж цэрэг, цагдаагийн албан хаагч бүрийн нэг бүрийн иж бүрэн хувцас, хэрэглэл, зэвсэглэл”-ийг хэлнэ⁵ гэж тодорхойлсон байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулж Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль⁶ батлагдан гарсан юм.

Тус хуулинд хууль сахиулагч албан үүргээ гүйцэтгэх үедээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх харилцааг зохицуулах холбогдох хууль батлагдаж, хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд цагдаагийн байгууллага, алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 33.6-д заасан биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ энэ хуулийн 17-21 дүгээр зүйлд заасныг баримтална⁷ гэжээ.

Өөрөөр хэлбэл галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүчийг хэрэглэхдээ тус хуулийн 17-21 дүгээр зүйлд заасан үндэслэл журмыг цагдаагийн алба хаагч баримтлан ажиллахыг зүйл заалт бүрээр нарийвчлан тодотгож оруулсан байна.

Цагдаагийн албаны тухай хуулийг цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байгаатай холбогдуулан 2010 оны Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан “Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар нь хүчингүй болсон бөгөөд одоо Хууль зүйн сайд, Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан 2014 оны А/126 тоот тушаал⁸ -ыг мөрдөн ажиллаж байна.

Тус тушаалын хавсралтаар батлагдсан зааварт цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах албаны галт зэвсэг, тусгай хэрэгслийн жагсаалт болон тэдгээрийг алба хаагч нь хэрхэн яаж ямар Цагдаагийн албаны тухай хуулийн 28-р зүйлийн 28.1 дэх заал аргачлалаар хэрэглэхийг тусгайлан заасан ба Цагдаагийн албаны тухай болон Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн галт зэвсэг, тусгай хэрэгслийн заалтын үзэл баримтлалд нийцүүлсэн байна.

Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааварт цагдаагийн алба хаагчаас цахилгаан гүйдлээр цохигч бууг /“Taser X-26” загварын цахилгаан буу/ хэрхэн ямар аргаар ашиглах, анхаарвал зохих зүйлийн талаар тусгаж өгсөн нь цагдаагийн албанд сүүлийн үеийн дэвшилтэт шинэ төрлийн тусгай хэрэгслийг хэрэглэх анхны

³ Цагдаагийн албаны тухай хуулийн 28-р зүйлийн 28.1 дэх заалт

⁴ Цагдаагийн албаны тухай хуулийн 28-р зүйлийн 28.3 дахь заалт

⁵ С. Нарангэрэл “Эрх зүйн толь бичиг” 2008 он

⁶ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь 2014 оны 01-р сарын 16-нд батлагдсан 22 зүйлтэй хууль юм.

⁷ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 16-р зүйл

⁸ ХЗС-ын 2014 оны 07-р сарын 10-ны өдөр баталсан “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар

эхлэл болсон юм. Үүнийг тодруулбал:

□ Хуульд заасан үндэслэлээр цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгыг тодорхойлж цахилгаан гүйдлээр цохигч бууг 4-5 метрийн зайд байгаа хүний биед чиглүүлэн хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж хэрэглэх ба энэ хугацаа нь араатан амьтанд 5 секундээс илүүгүй байхаар тооцогдоно.

1. Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэхэд тохиромжтой бөгөөд нүүр, толгойн хэсэгт хэрэглэхийг хориглоно. Боломжтой бүх тохиолдолд хүний биеийн ил харагдах хэсэгт хэрэглэхийг хориглоно.

2. Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны үйлчлэл нь хүний биеийн булчинлаг хэсэг зангирах, өвдөлт өгөх, мэдрэлийн систем түр сарних хэлбэрээр 5 минут үйлчлэх бөгөөд 20 минутын дараа үйлчлэл бүрэн арилна.

3. Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны хэвийн ажиллагааг шалгаж, унтраалгыг ажиллуулсан байх бөгөөд бороо, устай газарт хэрэглэхээс зайлсхийх, чийгтэй газарт хадгалахыг хориглоно гэж⁹ тус тус тодорхойлсон байна.

Гадаадын өндөр хөгжилтэй болон хөгжингүй орнуудын цагдаа болон хууль сахиулах бусад байгууллага нь өөрийн хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ гүйцэтгэхдээ албаны үйл ажиллагаандаа цахилгаан гүйдлээр цохигч буу буюу “Taser X-26” загварын бууг өргөнөөр ашиглаж байна.

Тухайлбал манай хойд, урд хөрш болох ОХУ, БНХАУ болон АНУ, Англи, Израль, Энэтхэг гэх зэрэг улс орны цэрэг, цагдаа болон хууль сахиулах салбарын алба хаагч нь гэмт этгээд болон зөрчил гаргасан хүний хууль бус үйлдлийг таслан зогсоох, саатуулах, баривчлах, аюулгүй байдлыг хангах үедээ “Taser X-26” загварын цахилгаан бууг ашиглаж байна.


Тус цахилгаан бууны ажиллах зарчим, техникийн үзүүлэлт, хүний биед хэрхэн нөлөөлөл үзүүлдэг талаар товчхон авч үзье.

Энэхүү цахилгаан буу нь цахилгаанаар цочрол өгөх замаар төв мэдрэлийн системд нөлөөлж, ингэснээр булчингийн үйл ажиллагааг түр зогсоох үйлчлэл үзүүлнэ. Тус буугаар буудуулсан этгээд нь ямар нэгэн үйлдэл хийх чадамжгүй, өөрийн биеийг хянаж чадахгүй болж, газарт шууд унадаг байна. Цахилгаан үйлчлэл нь тухайн хүнд үйлчлэхээс өөр хүнд үйлчлэхгүй.

“Taser X-26” загвары цахилгаан бууны ерөнхий загвар байдал, бүтэц зохион байгуулалт, эд анги нь дараах байдалтай байна.¹⁰


⁹ Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”-ын 3.6.3 дахь хэсэг. 2014 он

¹⁰ www.taser.com




Тус "Taser X-26" загварын цахилгаан бууг ашиглаж байгаа тухайн алба хаагч нь бууг дараах байдлаар ашиглаж болно. Үүнд:

- ☐ Цахилгаан бороохой байдлаар тулгаж хэрэглэх
- ☐ Цахилгаан буу байдлаар тодорхой зайнаас хэрэглэх




"Taser X-26" загварын цахилгаан бууны техникийн өгөгдөлүүн

- ☐ 2 цахилгаан дамжуулах шон нь 48м/1 сек хурдтайгаар гардаг.
- ☐ Буудах холын зай нь 4,6 м—7.6 м
- ☐ Хараа болон лазерыг ашиглах боломжтой.
- ☐ 2 цахилгаан шонгийн хооронд 8 градусын өнцгөөр 30 см зайтай байхаар тооцож буудна.
- ☐ Нүүр, хоолой, хэвлийн тус газар буудахаас сэргийлэх хэрэгтэй.
- ☐ 2 цахилгаан шонгийн хоорондын зай хол байх тусмаа үзүүлэх нөлөөлөл сайн байна.



(m)	1.5m	2.1m	3m	4.5m	6.4m	7.6m
Target Distance (ft)	2'	5'	7'	10'	15'	21'
Spread (in)	4"	9"	13"	18"	26"	36"
38"						
(cm)	10cm	23cm	33cm	46cm	66cm	91cm



"Taser X-26" загварын цахилгаан бууны 2 шон байнд зоогдсоны дараагаар 1 удаагийн цохилтоор 5 секундын давтамжтай хугацаанд шонгийн утсаар дамжин цахилгаан цохино.




Хүний биед дараах нөлөөллүүд үзүүлнэ. Буудуулсан даруйд газарт унана. /Хөдөлгөөн хязгаарлана. Явах чадваргүй болгоно. /Хашгирна, орилно./Бие организмд тодорхой өөрчлөлт орж өвдөлт мэдрэнэ./



-
- Булчингуудыг хүчээр зангируулна. /Хүний биеийн булчингийн үйл ажиллагааг саармагжуулж зогсооно./

- Байсан газар дээрээ хөдөлгөөнгүй болно. /Эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болгож илүү хөдөлгөөн хийхгүй байх нөхцлийг бүрдүүлнэ./
 - Хэдэн секунд/минут толгой эргэнэ. /Тодорхой хугацаанд толгой эргэх, дотор муухай оргих, огиулах шинж тэмдэг илэрнэ./
- Хүний биед дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ.



Арьсанд гүнзгий орсноос арьсанд шархлаа үүсгэж, удаан эдгэхгүй байх боломжтой. /Гоо сайхан, гадаад үзэмжинд нөлөөлөх, шарх сорвитой болох Нүдэнд гэмтэл учруулж болзошгүй. / Хараа муудах, нүд сохрох, бусад эрсдэл дагуулах/

- Шатамхай шингэнд гал авалцуулна./Бензин, шатахуун болон шатах тослох материалтай газар орчин нөхцөлд аль болох хэрэглэхгүй байх, шаардлагатай тохиолдолд аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нарийн чанд мөрдөж ажиллах/
- Унаснаас болж дагалдах гэмтэл учруулж болзошгүй. /Хүний биеийн хүндийн төв хаашаа хазайна тэр талруу буудуулсан этгээд унадаг тул тухайн унаж байгаа газар, орчин нөхцөлд хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах магадлал өндөр байна. Жишээ нь: Хурц ирмэгтэй эд зүйл, хутга мэс гэх мэт/
- Өвдөлт үүсгэж, стрессд оруулж болзошгүй. /Тухайн этгээд цахилгаан буугаар буудуулснаар бие организм тодорхой өвдөлт мэдрэх, сэтгэл санаа цочирдох ингэснээр айдас хүйдэст автагдах/

Мөн тус цахилгаан гүйдлээр цохигч бууг ашиглаж байгаа алба хаагч нь өөрийн аюулгүй байдлаа хангаж ажиллах зорилгоор албан үүргээ гүйцэтгэх үедээ тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийг ашигладаг байна.Тухайлбал: Тусгай зориулалтын малгай, подволька, бээлий, борооны цув, хантааз гэх мэт. Ингэснээр гэмт этгээд тус цахилгаан гүйдлээр цохигч бууг алба хаагчийн эсрэг хэрэглэсэн тохиолдолд аливаа нэг эрсдэл, хохирол учруулахгүй бөгөөд амь нас, эрүүл мэндийг нь хамгаалаад зогсохгүй бусад сөрөг нөлөөллөөс хамгаалж чаддаг байна. Тус хувцас, хэрэглэл нь тусгай зориулалтын материаллаар хийгдсэн байдаг бөгөөд хэрхэн яаж хэрэглэх, анхаарах зүйлийн талаар сургагч багш нар нь тусгайлсан кабинет, өрөө тасалгаа, талбайд алба хаагчдад сургалтыг зохион байгуулан явуулж улмаар мэдлэг, ур чадвар, дадал олгодог байна.

Цахилгаан гүйдлээр цохигч бууг цагдаагийн албаны үйл ажиллагаанд нэвтрүүлж гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах шууд чиг үүрэг бүхий алба хаагчдад тавьж олгосноор гэмт этгээд болон зөрчил гаргасан хүний хууль бус үйлдлийг таслан зогсоох, саатуулах, баривчлах ажиллагааг шуурхай явуулах таатай нөхцөл бүрдэж үр дүнтэй алхам болох юм. Нөгөө талаас үүргээ гүйцэтгэж байгаа алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж учирч болох эрсдлээс хамгаалахад онцгой ач холбогдолтой үр дүнтэй арга хэмжээ

болно.

Тухайлбал: 2011 онд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Нарантуул зах”-ын замын уулзар дээр албан үүргээ гүйцэтгэж байсан замын цагдаагийн алба хаагчийн хууль ёсны тавьсан шаардлагыг үл биелүүлэн улмаар эсэргүүцэл үзүүлэн зодож биед нь гэмтэл учруулсан үйл явдлыг жишээ болгон авч үзье.

Дээрхи нөхцөл байдалд цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх үедээ цахилгаан гүйдлээр цохигч бууг биедээ авч явсан бол гэмт хэрэг, захиргааны зөрчил гаргасан этгээдийн хууль бус үйлдлийг богино хугацаанд хязгаарлаж улмаар өөрийнхөө аюулгүй байдлыг бүрэн хангах боломжтой байхаар байсан байна.

Учир нь “Taser X-26” загварын цахилгаан бууг гэмт хэрэг, захиргааны зөрчил гаргасан хүнд хэрэглэснээр тухайн этгээдийн бие бялдар, тусгай бэлтгэл, албаны мэргэжлийн үйл ажиллагаанаас үл хамааран булчингийн үйл ажиллагааг түр зогсоох үйлчлэл үзүүлэн ямар нэгэн үйлдэл хийх чадамжгүй болгон хөдөлгөөнийг хязгаарлах нөхцлийг бүрдүүлж өгдөг байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллага, алба хаагч нь дотоодын холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу шаардлагатай тохиолдолд галт зэвсэг хэрэглэх эрх нээлттэй байгаа боловч үүнээс аль болох түдгэлзэх, боломжтой бүх тохиолдолд олон улсын жишигт нийцсэн орчин үеийн дэвшилтэт техник, тусгай хэрэгслийг /“Taser X-26” загварын цахилгаан буу буюу аминд халгүй зэвсэг/ албаны үйл ажиллагаандаа ашиглах хэрэгцээ, шаардлага байна.

“Taser X-26” загварын цахилгаан бууг цагдаагийн албанд нэвтрүүлж холбогдох зааврын дагуу хэрэглэснээр хүний амь насанд шууд хохирол учруулахгүй, алба хаагч хүчийг зөв тохируулан хэрэглэх, ингэснээр эрхээ хэтрүүлэхгүй байх үндсэн нөхцлийг бүрдүүлж хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг баталгаатай хангах цогц арга хэмжээ болох юм.

Санал:

“Taser X-26” загварын цахилгаан бууг цагдаагийн албаны үйл ажиллагаанд ашиглахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, ашиглах аргачлалыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулан хууль, эрх зүйн таатай орчин бий болгох

- “Taser X-26” загварын цахилгаан бууг ашиглах стандарт, журмыг мэргэжлийн байгууллагаар батлуулан гаргаж албанд мөрдлөг болгон ашиглах-

- “Taser X-26” загварын цахилгаан буугашиглах талаар тэргүүн туршлага хуримтлуулсан хөгжингүй зарим улс болох ОХУ, Энэтхэг, АНУ-ын аль нэгэнд 2-3 алба хаагч явуулж туршлага судлуулах

- Гадаад улсаас энэ чиглэлээр тусгайлсан албаны сургалт явуулдаг сургагч багш нарыг урьж авчиран сургалт зохион байгуулах

- Гадаадын сургагч багш, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор “Taser X-26” загварын цахилгаан буун дээр ажиллах 25-30 сургагч багш бэлтгэх, ингэснээр нийт бие бүрэлдэхүүнд бэлтгэгдсэн сургагч багш нар сургалтыг зохион байгуулах

- Сүүлийн үеийн дэвшилтэт шинэ төрлийн тусгай хэрэгсэл болох “Taser X-26” загварын цахилгаан бууг цагдаагийн төв байгууллагаас худалдаж авах ажил зохион байгуулж, алба хаагчид цагдаагийн албаны үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлэх.